



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/588

Булган сум

Гүйцэтгэгчтэй нэмэлт гэрээ байгуулах
эрх олгох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь заалт, Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн 75 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн XVII/01 дүгээр хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” тогтоолын 2 дугаар хавсралтын 2.17 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Булган аймаг, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ны хамтран ажиллах гэрээнд тусгагдсан Хангал сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажил гүйцэтгэгч “Тэнгэр хишиг” ХХК-ны барилгын материалын үнийн өсөлтийн зөрүү хөрөнгө Барилгын Хөгжлийн Төвийн 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 88-01/2023 дугаартай Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлтийн нэгтгэлээр 224,298,419.00 (хоёр зуун хорин дөрвөн сая хоёр зуун ерэн найман мянга дөрвөн зуун арван ес) төгрөгөөр хянагдаж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдсан тул гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-д олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

3. Гэрээнд заагдсан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Тэнгэр хишиг” ХХК-ийн захирал (Ж.Амаржаргал)-д даалгасугай.

4. Тус ажлыг хууль, журам, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

6323010632